



Authorized
Distributor



ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЦОГЦ ШИЙДЭЛ

Бүтээгдэхүүний каталоги



innochem.mn

**Agilent**Authorized
Distributor

Agilent Technologies Inc нь ердийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч бус биологийн шинжлэх ухаан, анагаах ухааны оношилгоо судалгаа болон хэрэглээний химийн зах зээлд тэргүүлэгч төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт буй лабораториудад тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, шинжилгээний арга аргачлалыг нийлүүлэхээс гадна хэрэглэгчдийн хайж буй эрэл хайгуулд ойлголт олж авахад нь чиглүүлж дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Agilent Technologies Inc-ийн мэргэжилтнүүдийн найдвартай түншлэлдээ тулгуурлан үйлчлүүлэгчдэд бүрэн цогц найдвартай шийдлүүдийг бидний зүгээс үзүүлж байна. Agilent Technologies Inc нь эмийн бодис, хүрээлэн буй орчин болон шүүх эмнэлэг, химийн бодис, эрчим хүч, материал судлал, хүнсний судалгаа шинжилгээ зэрэг 6 том зах зээлд төвлөрөн үйл ажиллагаа явуулж буй бөгөөд Монголын хэрэглэгчдэд бид нийгмийн амьдралын чанарыг сайжруулахыг туйлын зорилго болгон, мэдлэг туршлагаа үргэлжлүүлэн сайжруулж, цаашид анхаарч ажиллах болно.



ЭМИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Agilent Technologies Inc нь эмийн үйлдвэрлэлийн салбарт өргөн хүрээний шийдлүүдийг санал болгодог компаниудын нэг юм. Өвчний эмнэлзүйн судалгаа, эмийн нээлтээс өгсүүлээд эм боловсруулах, эмийн чанарын хяналтаас үйлдвэрлэл хүртэл Agilent Technologies Inc-ийн шийдлүүд нь эмийн бүхий л үйлдвэрлэлийн салбарт маш сайн нарийвчлалтай шинжилгээний үр дүнг хангаж өгдөг. Үйл ажиллагааны бүхий л явцыг хамарсан бүрэн шийдэл нь хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ зах зээлд илүү хурдан гаргах боломжийг бидний зүгээс нээж өгч байна. Agilent Technologies Inc нь мөн үйлчлүүлэгчдийн багаж хэрэгсэл болон тэдгээрийн үйл ажиллагаа нь хатуу чанд техникийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг мөн баталгаажуулдаг.



ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, ШҮҮХ ЭМНЭЛЭГ

Agilent Technologies Inc нь пестицидээс өгсүүлээд эмийн үлдэгдэл, ул мөрийн төдий агууламжтай хүнд металл зэрэг амьдралын чанарт нөлөөлдөг бохирдуулагчидийн хяналтанд хурдан, үнэн зөв, мэдрэх чадвар маш өндөр шинжилгээний аргуудыг санал болгодог. Agilent Technologies Inc-ийн шийдлүүд нь мөн хууль сахиулах байгууллагуудад маш чухал үүргийг гүйцэтгэдэг бөгөөд хүчирхэг багаж хэрэгслээр хангаснаар мөрдөн байцаалтын явцад нотлох баримтыг шинжлэж тогтоох, түүнчлэн дэлхийн шилдэг тамирчдын шударга өрсөлдөөнийг хангах допингийн шинжилгээ зэрэг г.м.



ХИМИЙН БОДИС, ЭРЧИМ ХҮЧ, МАТЕРИАЛ СУДЛАЛ

Хүн төрөлхтөний ирээдүй эрчим хүчгүйгээр оршин тогтнох боломжгүй, эрчим хүчний компаниуд түүнийг үйлдвэрлэх, боловсруулах болон эрэл хайгуулын судалгаа нь эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байх шаардлагатай. Agilent Technologies Inc-ийн шийдэл нь үйлчлүүлэгчдэд үйлдвэрлэлийн үр ашиг бүтээмжийг нэмэгдүүлэх, болзошгүй алдаа дутагдлаас урьдчилан сэргийлж шийдвэрлэхэд туслахаас гадна, ялангуяа шинжлэх ухааны судлаачдад био түлш, сэргээгдэх эрчим хүч болон бусад эрчим хүчний эх үүсвэрийн судалгааны хөгжилд ихээхэн хувь нэмрийг оруулдаг.



ХҮНС

Agilent Technologies Inc нь дэлхийн хүнсний хангамжийг химийн бодис, бактери, бичил биетэн зэрэг бохирдуулагч бодисоос ангид байлгахыг эрмэлздэг. Agilent Technologies Inc-ийн үйлчлүүлэгчид нь төрийн зохицуулалтын агентлагууд, хүнсний аюулгүй байдлын хяналтын лабораториуд, хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, савлаж олон нийтэд борлуулдаг хувийн хэвшлийн компаниуд байдаг.



СУДАЛГАА

Agilent Technologies Inc нь биологийн шинжлэх ухааны болон анагаах ухааны судлаачдад хорт хавдар, зүрх судасны өвчин, чихрийн шижин, Альцгеймерийн болон Паркинсоны өвчин, аутизм зэрэг бусад өвчний талаар илүү их мэдэхэд туслах төдийгүй Agilent Technologies Inc-ийн багаж хэрэгсэл, программ хангамж, дээж бэлтгэлийн шийдлүүд нь эрдэмтдэн судлаачдад илүү хурдан, үнэн зөв судалгаа хийхэд туслалцаа үзүүлдэг.



АНАГААХ УХААНЫ ОНОШЛОГОО

Agilent Technologies Inc нь хорт хавдар болон бусад өвчний эсрэг тэмцэлд ахиц дэвшил гаргахад эмч нарт ихээхэн хувь нэмрийг оруулж буй төдийгүй эмгэг судлалын лабораториуд нь эмнэлэг, тэдгээрт үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн төвүүдэд илүү хурдан, үнэн зөв мэдээллээр хангах, мөн түүнчлэн эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд үнэн зөв оношлоход тусласнаар өвчтөн илүү үр дүнтэй эмчилгээ үйлчилгээ авах боломжийг олгож байна.

АГУУЛГА

Дистрибьютерийн тухай	4
Хэрэгтэй мэдээллийг хаанаас авч болох вэ?	4
Agilent GC хийн хроматографийн хувьсал хийсэн, инновцлаг бүтээгдэхүүнүүд	5
Хийн хроматографийн дээж оруулагч төхөөрөмж	6
Agilent LC UHPLC шингэний хроматографи шийдлүүд	7
Agilent dissolution буюу уусгалтын төхөөрөмжийн шийдлүүд	9
Agilent GC/MS төхөөрөмжийн шийдлүүд GC-MS систем	10
Agilent LC/MS төхөөрөмжийн шийдлүүд LC/MS систем	11
Agilent AAS атом шингээлтийн спектрометрийн шийдлүүд	13
Agilent MS молекулын спектрофотометрийн шийдлүүд	14
Нил улаан туяаны (IR) спектрофотометрийн загварууд	15
Амьдралын шинжлэх ухааны хэрэглээний автоматжуулалтын шийдлүүд	16
Agilent Seahorse цуврал	17
Agilent бараж, тэдгээрийн удирдлагын Openlab систем	18
MassHunter ажлын станцын программ хангамж	19
Agilent дээж бэлтгэх	20
Agilent Багана	20
Бараж хэрэгсэл ба хэрэглээний зүйлс	21
Agilent химийн урвалж бодисын шийдлүүд	21

Дистрибьютерийн тухай

Медимпекс Интернэшнл ХХК нь 2008 оноос Монголын хэрэглэгчиддээ дэлхийн тэргүүлэгч технологи үйлдвэрлэгчидийн нэг Agilent Technologies Брэндийн бүтээгдэхүүн үйлчилгээг албан ёсоор хүргэн ажиллаж байна.

Лабораторийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулахаар зорин ажилладаг бид 2021 онд Демо лаборатори, 2023 онд Инно Хими Лаб ХХК охин компаниа байгуулан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ илүү ойртуулан хүргэж байна.

Олон жилийн турш үнэ цэнийг хадгалан, лабораторийн тань тасралтгүй ажиллагааг хангахын төлөө бид тасралтгүй суралцаж, судалж, хамтрах үнэ цэнтэй хамтрагч нь байхын төлөө ажиллах болно.



Хэрэгтэй мэдээллийг хаанаас авч болох вэ?

Agilent Technologies Inc-ийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч

Медимпекс Интернэшнл ХХК нь Монголд төлөөлөн ажилладаг. Мэргэшсэн инженерийн сервис үйлчилгээтэй. Түүний охин компани Инно Хими Лаб ХХК нь хамгийн сүүлийн үеийн мэдээллийг хэрэглэгчиддээ хүргэх, демо төвөөр дамжуулан сургалт зохион байгуулдаг.

Хариуцсан ажилтантай холбогдох

Agilent-ийн бүтээгдэхүүний хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, өөрийн оронд нэвтэрч буй шинэ технологи, тоног төхөөрөмжийн мэдээллийг <https://www.facebook.com/AgilentDemoCenter> фэйсбүүк хуудаснаас авах боломжтой.



Agilent – ийн брэндүүд

Agilent – ийн бүтээгдэхүүний хүрээ өдрөөс өдөрт өргөжин, салбартаа тэргүүлэгч брэндүүдийг нэгтгэсээр байна. Жилийн нийт бараа бүтээгдэхүүний эргэлт 6.4 тэрбум долларт хүрсэн амжилттай ажилладаг дэлхийн брэнд юм.

Agilent борлуулалтын үйлчилгээ

Та өөрийн лабораторийн тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлон сонгох гэж байгаа лабораторийн тоног төхөөрөмжийн талаарх асуултаа sales@innocchem.mn цахим хаягт илгээгээрэй. Мэргэжлийн, мэргэшсэн баг танд хариу өгөх болно.

Agilent-ийн борлуулалтын дараах үйлчилгээг

Та борлуулалтын дараах үйлчилгээг албан ёсны төлөөлөгч **Медимпекс Интернэшнл ХХК** болон **Инно Хими Лаб ХХК** хариуцдаг.

Agilent сургалт

Agilent-ийн хамгийн сүүлийн үеийн сургалтын мэдээлэл, сургалтыг онлайнаас англи хэл дээр авч болохоос <https://www.youtube.com/@InnoChemLab> хуудсаас Монгол хэл дээрх бичлэгүүдийг үзэх боломжтой. Инно Хими Лаб ХХК нь тоног төхөөрөмж ашиглалтын сургалтыг хариуцдаг.



Agilent онлайн мэдээлэл

Agilent-ийн бүтээгдэхүүн, сургалт, эвэнт, шийдлийн талаарх мэдээллийг <https://www.agilent.com/> вэбсайтаар нэвтрэн авах боломжтойгоос гадна өргөн хэрэглээний бүхий л сошиал сувгуудад Agilent Technologies нэрээр байршиж, хэрэглэгчийн үйл ажиллагааг дэмжсэн бүхий л төрлийн контентийг судлах боломжтой.

Лабораторийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс хэрэглэгчиддээ Монгол дахь албан ёсны дистрибьютерийн зүгээс мэдээллийг тогтмол бэлтгэн хүргэдэг. Та info@innocchem.mn хаягт хүсэлтээ илгээн нэгдэх боломжтой.



Agilent GC хийн хроматографийн хувьсал хийсэн, инновцлаг бүтээгдэхүүнүүд

8890 ХИЙН ХРОМАТОГРАФИ (8890 GC)

Agilent 8890 GC загвар нь хүчирхэг электроникийн зохион байгуулалтын бүтэцтэй, ажлын цар хүрээ онцгой өргөн, аж үйлдвэрийн 4.0 хувьсгал болох дижитал шийдлийг шингээсэн ба өмнөх хийн хроматографийн загваруудын сайн талыг ухаалаг алгоритм бүхий хос цөмт процессороор баяжуулж өгснөөр оношилгоо болон таньж тодорхойлох функц нь дэвшилтэт шинэ шатанд гаргасан бөгөөд лабораторийн бүтээмж болон хэмжилтийн үр дүнгийн үнэн зөв байдлыг өндөр түвшинд хангасан шинжилгээний төхөөрөмж юм.



8890 GC

8860 ХИЙН ХРОМАТОГРАФИ (8860 GC)

Лабораторийн өдөр тутмын ердийн шинжилгээнд зориулсан сонгодог хийн хроматографийн энэхүү загвар нь 8890-тэй ижил үндсэн бүтэцтэй боловч хэрэглээний цар хүрээ өргөн, шинжилгээний хувирах чадвар уян хатан бөгөөд 3 детектор, 3 хавхлага, 6 халаалтын бүсээр тохируулах боломжтой, сонгодог өнгөт мэдрэгчтэй дэлгэц, хэрэглэгчийн интерфэйс хөтөч, ухаалаг харилцаа холбоо бүхий алсын удирдлагатай хослуулсан нь лабораторийн өдөр тутмын шинжилгээнд үнэхээр төгс шийдэл юм.



8860 GC

7820A VL ХИЙН ХРОМАТОГРАФИ (7820A VL GC)

Agilent-ийн хосгүй GC туршлага, салбартаа тэргүүлэгч чанарыг өвлөснөөр хэрэглэгчдэд өдөр тутмын шинжилгээнд найдвартай үр дүнг өгөхийн сацуу шинжилгээний хүндрэлийг багасгадаг. Оролт болон детекторын аль алиныг нь электрон хийн тохируулагчтай (EPR) бөгөөд оролтын хийн урсгалыг электрон хийн удирдлагаар (EPC) тохируулан ашиглах боломжтой. Agilent Technologies Inc-ийн хийн фазын бүтээгдэхүүний цувралыг 7820A VL нь загвар нь баяжуулаад зогсохгүй, хязгаарлагдмал төсөвтэй хэрэглэгчид зориулсан хэмнэлттэй, өндөр гүйцэтгэлийг хослуулахын зэрэгцээ, Agilent Technologies Inc-ийн найдвартай технологи, чанар, болон үйлчилгээг авах боломжтой.



7820A VL GC

990 БИЧИЛ ХИЙН ХРОМАТОГРАФИ (990 MICRO GC)

Салбартаа тэргүүлэгч Инновацилаг шинж чанаруудыг шингээсэн өндөр чанартай, хурдан шинжилгээний горим зэрэг нь хийн шинжилгээнд чухал үүрэг гүйцэтгэх ба танд хэрэгтэй баталгаатай шинжилгээний үр дүнг өгнө. Илрүүлэх болон ялган салгалтын 4 хүртэлх сувагтай ба бичил дулаан дамжуулалтын детектор (uTCD) нь уламжлалт лабораторийн хийн хроматографийн төхөөрөмжийн цахилгаан болон зөөгч хийтэй харьцуулахад ердөө 10%-ийг л зарцуулдагаараа давуу талтай юм.



990 MICRO GC

ИНТУВО 9000 ХИЙН ХРОМАТОГРАФИ (INTUVO 9000 GC)

Хийн хроматографийн технологийн салбарт тэргүүлэгчийн дараагийн үеийн GC төхөөрөмж

Интуво нь шинжилгээний хугацааг богиносгосон шууд халахаар зохион бүтээгдсэн дискэн баганатай бөгөөд баганыг нягт нямбай хурдан солих, жийргэвчгүйгээр битүүмжлэн хялбар түргэн холбох холбогчтой, чип хэлбэрийн хамгаалалтын баганын технологи нь багана тасдах залхмаар үйлдлээс ангижирсан ба сайжруулсан инерт урсгал нь өндөр мэдрэх чадвар, нарийвчлал болон таарц(reproducibility) олгохын сацуу шинэ авсаархан баганы загвар нь орон зайн эзлэх хэмжээг багасгаж, тогтвортой ажиллагааг хангасан тул танай лабораторит шилдэг Инновацийг авч ирэх болно.



INTUVO 9000 GC

AGILENT АНАЛИЗАТОРУУД БОЛОН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН БАГЦУУД

Хүнсний үйлдвэрлэл, хүрээлэн буй орчин, шүүхийн шинжилгээ, нефть хими г.м нийтлэг салбаруудын стандартад үндэслэсэн төрөл бүрийн анализаторууд нь танай лабораторийн шинжилгээний чадавхи, хурдыг нэмэгдүүлэх боломжтой. Agilent GC, бичил GC, GC/MS болон GC/MS/MS төхөөрөмжүүд нь таныг хамгийн богино хугацаанд ажиллахын тулд үйлдвэрлэгчээс урьдчилан туршилт тохируулгыг хийсэн.

Хийн хроматографийн дээж оруулагч төхөөрөмж

7696А ДЭЭЖ БЭЛТГЭГЧ (7696А SP)

Энэхүү төхөөрөмж нь хий болон шингэний хроматографийн сорьцын саванд дээжийг АНУ-ын бүтээгдэхүүний стандарт болох ASTM болон европийн холбооны EN стандартын шаардлагын дагуу өндөр нарийвчлалтайгаар тооцоолж жинлэх чадвартай төхөөрөмж юм.



7696А дээж бэлтгэгч

7650А АВТОМАТ ШИНГЭНИЙ ДЭЭЖ АВАГЧ (7650А ALS)

Автомат шингэний дээж авагч 7650А нь 50 хүртэлх дээжийг багтаах ба хурдан тарилтын технологи нь сорьцын задрал болон тариурын зүүний гэмтлийг бууруулсаны ачаар хэрэглэгчдэд илүү олон сонголтыг хийх боломжийг олгохын сацуу лабораторийн ажлын урсгалыг оновчтой төлөвлөх боломжтой болсон.

7693А АВТОМАТ ШИНГЭНИЙ ДЭЭЖ АВАГЧ (7693А ALS)

Автомат шингэний дээж авагч 7693А нь дээжийг нэгэн зэрэг, хурдан тарих технологийн аль алиныг нь багтаасан хос цамхагтай загвар ба шинжилгээний ажлын бүтээмж, гүйцэтгэл болон уян хатан чанар, хүчирхэг сорьц бэлтгэлийн ажиллагааг шингээсэн дэвшилтэт дээж авагч юм.



7693А автомат шингэний дээж авагч

8697 УУРЫН ФАЗЫН ДЭЭЖ АВАГЧ (8697 HEADSPACE SAMPLER)

Уурын фазын дээж авагч 8697-ийн тусламжтай дээжийг хялбархан боловсруулж өөрт хэрэгтэй шинжилгээний үр дүнг цаг алдалгүй гарган авах боломжтой дээж авагчийн шийдэл юм. Энэхүү дээжлэгч нь атмосферийн даралтыг нөхөх боломжтой, хийн урсгалыг тохируулагчтай бичил салаалагч EPC модул, шинжилгээний гүйцэтгэл болон өндөр нарийвчлал бүхий дээж хувиарлаж оруулах хавхлаг зэрэг дэвшилтэт технологийн шийдлийг шингээсэн төхөөрөмж бөгөөд ухаалаг холболтын систем бүхий Agilent Technologies Inc 8890, 8860 болон Intuvo 9000 GC зэрэг хийн хроматографиудтай хялбархан холбогдож, эдгээр төхөөрөмжүүдийг лабораторид байгаа эсэхээс үл хамааран хөтчийн интерфэйсийн тусламжтай алсаас удирдан ажиллуулах боломжтой юм.

ОЛОН ҮЙЛДЭЛТ PAL ЗАГВАРЫН АВТОМАТ ДЭЭЖ АВАГЧ (PAL3 SAMPLER)

Дээд зэрэглэлийн PAL3 дээж авагч нь уурын фазын (Headspace), хатуу фазын бичил хандлалтын (SPME) болон шингэний зэрэг дээж оруулах 3 тарилгын арга техникийг багтаасан бөгөөд лабораторид GC болон GC-MS-ийн бүтээмжийг илүү сайн хангаж өгдөг.



8697 уурын фазын дээж авагч

ДУЛААНЫ ДЕСОРБЦИЙН ДЭЭЖ АВАГЧ (THERMAL DESORPTION/TDS)

Энэхүү дээж оруулах технологийг хүүхдийн тоглоом, барилгын материал, машины доторлогооны материал, хоол хүнс, агаар дах дэгдэмхий бохирдлуудыг хэмжихэд ашиглах төдийгүй шүүх эмнэлэг, батлан хамгаалахын салбарт болон өдөр тутмын агаарын бохирдлын ялгаралын түвшинг тодорхойлох шинжилгээнд ашиглах боломжтой.

ЧӨЛӨӨЛӨН БАРИХ ДЭЭЖ АВАГЧ (PURGE AND TRAP SAMPLER)

Төрөл бүрийн матрицаас дэгдэмхий органик нэгдлүүдийг цэвэрлэж зайлуулах замаар шинжлэгдэхүүнийг барьж тодорхойлох дээж бэлтгэлийн дэвшилтэт арга. AQUATek 100 загварын чөлөөлөн цэвэрлэж, хуримтлуулан баяжуулах автомат дээж авагч (усны сорьцын) нь шингэн дээжийн шинжилгээнд 100 хуруу шилэнд дээжийг урьдчилан боловсруулж тодорхойлох боломжийг олгодгоороо давуу юм.



TDX 100-xr

Agilent LC UHPLC шингэний хроматографи шийдлүүд

1290 INFINITY II LC

Хэт өндөр даралттай шингэний хроматографийн (UHPLC) ирээдүйн чиг хандлагыг тодорхойлогч – дээд зэргийн тогтвортой, бат бөх чанар, дэвшилтэт технологиор хавсран нэмэгдүүлсэнээр шинжилгээний, тоног төхөөрөмжийн болон лабораторийн бүтээмж зэрэг гурван чиглэлээр таны бизнесийн үр ашгийг эрс сайжруулах боломжтой.

1260 INFINITY II LC

Энэхүү загвар нь үнийн хувьд ердийн HPLC-тэй ижил хэдий ч гүйцэтгэл, найдвартай байдлын өндөр стандартыг бий болгосон төдийгүй UHPLC түвшний шинжилгээний бүтээмж, өгөгдлийн чанар болон найдвартай байдлыг өөртөө шингээсэн хүчирхэг төхөөрөмж юм.

1260 INFINITY II PRIME LC

Agilent 1260 Infinity II LC цуврлын хамгийн хүчирхэг, тохиромжтой 5 мл/мин хүртэл урсгалын хурд болон 800 бар хүртэлх хүчин чадалтай шингэний хроматографийн загвар. Уг төхөөрөмж нь 1290 Infinity II-ийн шалгарсан найдвартай технологийг шингээсэн тул энэхүү систем нь таны өдөр тутмын ажилд ашиглахад хамгийн хялбар, баялаг функцтэйгээрээ давуу талтай.

1260 INFINITY II PRIME ONLINE LC

Agilent 1260 Infinity II Prime Online LC загвар нь үйлдвэрлэлийн процессийн шинжилгээний төхөөрөмж ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцын хяналтыг автоматжуулах, бүтээгдэхүүний чанарын нэн чухал үзүүлэлтүүдийг өндөр нарийвчлалтайгаар бодит цаг хугацаанд үнэн зөв хянаж тодорхойлохоор бүтээгдсэн шинжилгээний төхөөрөмж юм. Энэхүү загвар нь эмийн үйлдвэрлэлийн салбарт процессийн шинжилгээний арга аргачлалыг ашигладаг эрдэмтэн судлаачдын хэрэгцээний шаардлагад бүрэн нийцсэн бөгөөд хурдтай өрнөж буй үйлдвэрлэл процессийн явцад ямар нэгэн дээж бэлтгэлгүйгээр бүтээгдэхүүнийг бодит цаг хугацаанд нь хянадаг шингэн хроматографийн шийдэл юм.

1220 INFINITY II LC

Өдөр тутмын HPLC болон дэвшилтэт UHPLC-ийн шинжилгээний арга аргачлалыг шингээсэн өндөр чанартай цогц технологийн шийдэл 1220 Infinity II нь газар дээр нь шинжилгээг гүйцэтгэх боломжтой, явуулын лабораторийн зориулалтаар тоноглож бүтээгдсэн энгийн хялбар ажиллагаатай загвар юм.



1290 Infinity II



1260 Infinity II



1260 Infinity II Prime



1260 Infinity II Prime
Online



1220 Infinity II

Шингэний хроматографийн ажлын болон шинжилгээний арга аргачлалын шийдлүүд

1290 INFINITY II 2D-LC ШИЙДЭЛ – шинжилгээний хугацаа болон төхөөрөмж дээрх даралтыг нэмэгдүүлэхгүйгээр шинжилгээний аргаараа пикийн багтаамжийг ихээхэн нэмэгдүүлэх боломжтой шийдэл. Энэхүү шийдэл нь нэг болон хэд хэдэн шинжлэгдэхүүнийг ялган дүйх, өндөр нарийвчлалтайгаар 2 хэмжээст (2D) аргачлалаар сорьц авах болон бүтэн 2 хэмжээст (2D) аргачлалаар ялган салгах горимыг идэвхижүүлэх зэрэг шингэний хроматографийн нэг болон хоёр хэмжээст UHPLC-ийн хооронд хялбархан шилжих боломжтой юм.

MDS – нь автоматжуулсан шингэний хроматографийн аргын илрүүлэлт/төхөөрөмжийн боловсруулалтын шийдэл бөгөөд төхөөрөмж болон програм хангамж нь өөрөө тухайн шинжилгээнд тохирсон шингэний хроматографийн аргыг ухаалгаар автоматжуулж, үнэлэлт дүгнэлтийг гаргаж өгдөг.

Хавхлагат автматжуулалтын шийдлүүд –хурдан шилждэг олон төрлийн хавхлагууд нь дээжийг онлайнар урьдчилан боловсруулах (Online SPE), LC/MS-ээр бохирдлыг таньж тодорхойлох шинжилгээнд дэгдэмхий бус давсыг автоматаар зайлуулах, автоматаар баганыг дахин идэвхижүүлж цэвэрлэх болон хоёр хэмжээст хроматографийн аргаар шинжлэгдэхүүнийг ялган дүйх зэрэг янз бүрийн автоматжуулалтын шийдлүүдийг хурдан загварчилж бүтээх боломжтой.

1260 INFINITY II BIO-INERT LC ШИЙДЭЛ – Биологт макромолекулын шинжилгээнд зориулсан шийдэл. Энэхүү шинэ загвар нь дээж болон шингэн явах гуурсан технологит нь ямар нэгэн метал эд анги ороогүй тул биомолекулуудын бүрэн бүтэн байдлыг хадгалах, гадаргуугийн харилцан үйлчлэлийг багасгаж, баганын ашиглалтын хугацааг уртасгасан. Үүнийг уусгагч эсвэл pH-ийн нөхцөл нь эрс тэс үед ашиглах нь тохиромжтой.

1290 INFINITY II BIO-LC ШИЙДЭЛ –Давсны агуулга өндөр ба эрс тэс pH-ийн нөхцөлтэй био бэлдмэлийн болон бусад шинжилгээний аргын үед биомолекулын бүрэн бүтэн байдлыг нь хадгалдаг, системийн тогтвортой байдлыг хангахуйц биологийн нийцтэй материал бүхий бинар UHPLC-ийн төхөөрөмжийн шийдэл

1260 INFINITY II SFC ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЙДЭЛ – Уламжлалт HPLC-ийн төгс сайжруулсан өргөтгөл бөгөөд ялган салгахад хүндрэл ихтэй буюу хираль нэгдлүүдийг шинжлэгээнд маш сайн нарийвчлал болон нягтаршалтай хроматографийн шалгарсан арга техникийн шийдэл юм.

GPC/SEC-ийн БАГАЖ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИЙДЭЛ – Гель нэвчилтийн (GPC) болон хэмжээгээр нь ялган дүйх хроматографи (SEC) нь полимерийн молекул массын тархалтаар нь болон молекулын массын шинж чанараар нь хурдан бөгөөд найдвартай тодорхойлох шинжилгээний арга аргачлал юм. Бага тархалттай дифференциал детектор бүхий GPC-ийн төхөөрөмжийг бага молекул жин багатай шинжилгээний баганатай хослуулснаар олигомеруудын үр дүнтэй ялган салгадаг. Зуурамтгай чанар болон/эсхүл лазер сарнилтын детектороор тоноглогдсон төхөөрөмжийн тусламжтайгаар молекул жингийн илүү нарийвчилсан мэдээлэл, уургийн агрегат төлөв байдлын эмзэг, онцгой мэдээллийг илүү авахаас гадна молекулын хэмжээ, салбарлалтын зэрэг г.м полимерийн бүтэц, морфологийн мэдээллийг олж авах боломжтой юм.

Лабораторийн цэвэршүүлэх технологийн үр ашгийг нэмэгдүүлэх

Agilent Technologies Inc нь цэвэршүүлэлтийн асуудлыг шийдвэрлэхэд тань туслах болно. Бидний шийдэл нь гурван чиглэлээр үр ашгийг дээшлүүлснээр таны судалгаа шинжилгээ, ажлын амжилтыг баталгаажуулна.

Цэвэршүүлэх үр ашиг – InfinityLab LC цэвэршүүлэлтийн шийдлийн тусламжтай хамгийн өндөр цэвэршилттэй, сэргээгдэх чадвар өндөртэй ялгалтыг олж авах боломжтой. Ингэснээр массын фракциар нь ялгахаас өгсүүлээд олон төрлийн детектор ашиглах явцад дурын нэгдлийг алдахаас зайлсхийж болно.

Багажны үр ашиг – Хувьсах урсгалын хурдтай болон багтаамжтай үед миллиграммаас грамм хүртэлх хэмжээтэй дээжийг ямар ч алдагдалгүйгээр цэвэршүүлнэ. Төхөөрөмжийн цэвэр, эмх цэгцтэй үйл ажиллагаа нь таны өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулна.

Лабораторийн үр ашиг – Өсөн нэмэгдэж буй бизнесийн хэрэгцээнд тулгуурлан сайжруулан шинэчлэгдэх боломжтой, зай талбай бага эзэлхийн сацуу лабораторийн дотоод үйл ажиллагааг найдвартай хангаж, аюулгүй хамгаална.



1290 Infinity II



1290 Infinity II



1290 Infinity II



1290 Infinity II

Agilent dissolution буюу уусгалтын төхөөрөмжийн шийдлүүд

708-DS УУСГАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ

Таны боловсруулсан арга аргачлал, стандарт ажлын зааварт нийцүүлэн уян хатан хялбархан тохируулах боломжтойгоос гадна гадаад орчны өөрчлөлтөөс үүдэлтэй аливаа алдааг арилгах эсвэл багасгах боломжтой бөгөөд энэхүү төхөөрөмжийн гүйцэтгэлийн механик үзүүлэлтүүд нь олон улсын хүнс, эмийн стандартын чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурыг бүрэн хангасан бүтээгдэхүүн юм.



708-DS

NanoDis® УУСГАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ

Уламжлалт уусгалтын төхөөрөмжийг ашиглан автоматжуулсан, зүй зохистой горимоор эмийн идэвхитэй найрлагыг үнэн зөв дүрслэл болон томьёоллыг эрдэм шинжилгээний ажилтан болон судлаачдад олгож байдаг. Энэхүү чадварыг нь ашиглан шинжээчид эгэл хэсгийн хамгийн сайн жорыг томьёолон хурдан тогтоож, шинэ эмийн бэлдмэлийг зах зээлд гаргах хугацааг хурдасгах боломжийг олгодог.



BIO-DIS

BIO-DIS УХРАХ, ДАВШИХ ХӨДӨЛГӨӨНТ УУСГАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ

Энэхүү автомат уусгалтын төхөөрөмж нь АНУ (USP) болон Европийн холбооны (EP) эмийн стандартын гүйцэтгэлийн үзүүлэлтийн шаардлагад нийцсэн бөгөөд өөр өөр төрлийн найрлагатай, өөр өөр орчин шаарддаг уусгалтын туршилтанд зориулагдсан

400-DS 7 УУСГАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ

Эмийн бүтээгдэхүүний хоршил, зохицолын уусгалтын туршилт сорилыг туршилтын эзэлхүүний багтаамж бага нөхцөлд явуулахад зориулсан анхны уусгалтын төхөөрөмжүүдийн нэг ба эмийн бодисын туршилт сорилын USP 7 стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн. АНУ-ын хүнс, эмийн агентлагийн (FDA) электрон бүртгэл, хөтлөлтийн 21 CFR Part 11 стандартын шалгуурт нийцсэн эл бүтээгдэхүүн нь ажлын бүтээмж, үр ашиг, уян хатан байдлыг таньд өндрөөр үзүүлж чадна.



400-DS 7

BIO-DIS APPARATUS 3/7 УУСГАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ

Энэхүү автоматжуулсан уусгалтын сорилын төхөөрөмжийг туршилтын эзэлхүүний багтаамж бага, орчныг нь өөрчлөх шаардлагатай эсхүл эрчимтэй сэгсрэх шаардлагатай туршилтын нөхцөлүүдэд болон төрөл бүрийн бэлдмэлийн боловсруулалтын шатанд тохиромжтой.

850-DS УУСГАЛТЫН ДЭЭЖ АВАГЧ ТӨХӨӨРӨМЖ

Энэхүү уусгалтын дээж авагч нь дээжийг хадгалах, уусгалтын сорилын дээжийг автоматаар оруулах, олгохын сацуу дээжийг шилжүүлэх, шүүх болон цуглуулах зэрэг олон үйлдлийг автоматжуулж хялбаршуулсан ухаалаг төхөөрөмж юм.



850-DS

280-DS ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН МЕХАНИКЖСЭН ТӨХӨӨРӨМЖ

Зөөврийн механикжсэн чанарын баталгаажуулалтын төхөөрөмж нь дурын уусгалтын сорилыг өндөр нарийвчлалтайгаар дэвшилтэт сенсор технологийн тусламжтай маш богино хугацаанд критик физик үзүүлэлтүүдийг хэмжих бөгөөд туршилтын өгөгдлийн цогц тайланг дахин тооцоолох шаардлагагүйгээр гарган өгөх чадамжтай.

UV-VIS СПЕКТРОФОТОМЕТР БОЛОН УУСГАЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨГС ХОСЛОЛ

Уусгалтын төхөөрөмжийг диод матрицийн детектор бүхий Cary 8454 UV-Vis эсхүл Cary 60 UV-Vis загварын спектрофотометртэй хослуулан олон төрлийн бүтээгдэхүүний туршилт шинжилгээний аргыг дэмжих уян хатан шийдлийг бий болгох бололцоотой.

БҮРЭН АВТОМАТ ОПТИК МЯНДАС МЭДРЭГЧ БҮХИЙ УУСГАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ

Бодит цаг хугацаанд уусгалтын туршилтын муруйн диаграммыг гарган үзүүлэх чадамжтай эмийн бэлдмэл боловсруулах, уусгалтын туршилтын үр ашгийг үнэлэх боломжтой Cary 60 UV-Vis спектрофотометрээр тоноглогдсон хүчирхэг төхөөрөмж.



280-DS

AGILENT 100 –ЗАДРАЛЫН СОРИЛЫН АВТОМАТЖУУЛСАН ТӨХӨӨРӨМЖ

Бүх эмийн бүтээгдэхүүн нь задралын сорилыг явуулсан байх ба идэвхитэй эмийн бэлдмэл тодорхой орчин хоорондын харилцан үйлчлэлцлээр биологийн идэвхийн үнэлгээг тогтоодог. Энэхүү төхөөрөмж нь зай талбай бага эзэлдэг, олон улс орны эмийн стандартын шаардлагад нийцдэг нь түүнийг дурын стандартын шаардлагад тохирсон, найдвартай, уян хатан чанарыг хангадаг онцгой бүтээгдэхүүн болохыг илтгэдэг.

Agilent GC/MS төхөөрөмжийн шийдлүүд GC-MS систем

НЭГ КВАДРОПОЛИТ GC/MS СИСТЕМ

5977C GC/MSD – зөөгч хийгээр нь устөрөгчийг бүрэн орлуулан ашиглах боломжтой, ингэснээр гелийн зарцуулалтыг хэмнэж, шинжилгээний хурдыг сайжруулсан бөгөөд олон төрлийн ионжуулалтын горимоор шинжлэх ухааны өндөр түвшний судалгаанаас өгсүүлээд чанарын хяналтын ердийн шинжилгээ хүртэл янз бүрийн шинжилгээний салбарт ашиглах боломжтой.



5977C GC/MSD

ГУРВАЛСАН КВАДРОПОЛИТ GC/MS СИСТЕМ

7000E/7010C болон 7010D – масс спектрометрийн мэдрэх чадварыг фемтограммын (10-15) түвшинд хүртэл бууруулж сайжруулсан, өндөр хүчин чадал бүхий анхны гурвалсан квадруполит GC/MS нь ердийн (tMRM) болон динамик (dMRM) олон ион урвалын горимд ердөө нэг шинжилгээгээр олон зуун нэгдлүүдийг илрүүлж, тоон агууламжийг тодорхойлох чадвартай хүчирхэг төхөөрөмж юм.



7000E/7010C

КВАДРОПОЛИТ НИСЭХ ХУГАЦААНЫ GC/MS СИСТЕМ

7250 Q-TOF GC/MS – хэмжилтийн хурд 50 Гц-ийн давтамжтай нөхцөлд ч шинжлэх сорьцынхоо мэдээллийг бүрэн авч, нарийвчлалаа алдахгүйгээр массын өндөр нарийвчлалтайгаар хэмжилтийг хийх ба бага энергийн горимд ч гадаад ионжуулалтын (EI) үүсгүүр нь үл мэдэгдэх нэгдлийн чанарын шинжилгээнд молекул ионы пикийн эрчмийг нэмэгдүүлж сайжруулдаг.



7250 Q-TOF GC/MS

ТҮРГЭВЧИЛСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ QUICKPROBE GC/MS СИСТЕМ

Бодит хугацаанд ямар нэгэн дээж бэлтгэлийн арга ажиллагаа ашиглахгүйгээр нэг минутын дотор нунтаг, шахмал болон шингэн дээжийг шууд шинжлэнэ. Эгшин зуур ялган салгалт хийх чадвартай хийн хроматографийг хүчирхэг масс спектрометрийн детектортой хослуулан дээжийг шууд оруулах таригчтай бодит хугацааны шинжилгээ нь NIST спектрийн санг ашиглан илэрсэн нэгдлийг үнэн зөв найдвартай таньж тодорхойлох бөгөөд лабораторийн хүчин чадал, бүтээмжийг дээшлүүлэх төгс шийдэл юм.



QuickProbe GC/MS

GC/MS-ИЙН ТӨГС ХОСЛОЛ

Шинэ загварын Agilent Technologies Inc-ийн Intuvo 9000 GC хийн хроматографи нь масс спектрометрийн детектортой хосолсон төгс шийдэл юм. Хамгаалалтын Guard Column Chip технологийн шийдлийг шингээснээрээ баганыг хурдан халааж, хөргөхөөс гадна нь баганыг огтолж тайрах, баригдах хугацааг тохируулж барих, төхөөрөмжийн битүүмжлэлийн болон жийрэг феррулийн хийн алдагдалгүй холболтууд нь лабораторийн найдвартай ажиллагаа хангаж, өдөр тутмын шинжилгээнд дэмжлэг үзүүлэх ач тустай.



Intuvo 9000 GC

6100 ЗАГВАРЫН НЭГ КВАДРОПОЛИТ LC/MS СИСТЕМ

LC/MSD iQ - массын детекторын тусламжтай нэгдлүүдийг хурдан илрүүлж баталгаажуулах ба хэт ягаан туяаны детектороос илүү сонгомол, онцлог шинж өндөр юм. Хроматографийн аргаар салгах хүндрэлтэй нэгдлүүдийг ч масс спектрометрийн тусламжтай ялгаж, тэдгээрийг зөв таньж баталгаажуулж, илүү сонгомол, үнэн зөв үр дүнг өгдөг

6125 LC/MSD – үр дүнгийн баталгаажилт болон итгэлцлийг сайжруулахын тулд массын сонгомол илрүүлэлтийн хүчин чадлыг ашигладаг ахисан түвшний шинжилгээний төхөөрөмж юм. Энэхүү шийдэл нь 1260 эсхүл 1290 Infinity III LC шингэний хроматографийг массын сонгомол детектор болон програм хангамжтай нь хослуулснаараа лабораторийн үр ашгийг үр дүнтэй сайжруулах, хөрөнгө оруулалтын өгөөжийг олон дахин нэмэгдүүлнэ.

6135 LC/MSD XT нь таны хроматографийн төхөөрөмжийг массыг сонгомол илрүүлэлтийн хүчирхэг функцтэй хослуулснаар шинжилгээний найдвартай байдлыг үр дүнтэй сайжруулж, тоон шинжилгээний хэрэглээнд маш өндөр гүйцэтгэлийг авчрах болно. Энэхүү хослол нь массын өргөн мужид өндөр хурдтайгаар маш сайн мэдрэх чадварын тусламжтай илрүүлэлтийг гүйцэтгэдэг тул биомолекулын шинжилгээнээс гадна илрүүлэлтийн шинжилгээнд өндөр бүтээмжтэй, нарийн төвөгтэй матрицтай шинжилгээг хялбархан даван туулж чадна.

6200 ЗАГВАРЫН МАССЫН ӨНДӨР НАРИЙВЧЛАЛТАЙ НИСЭХ ХУГАЦААНЫ LC/MS ШИЙДЛҮҮД

6230B TOF LC/MS -Agilent Jet Stream Ion Focusing буюу даралтат урсгалтай ионыг чиглүүлэгч технологи ашигласнаар ердийн массын илрүүлтийг өндөр нарийвчлал бүхий массын илрүүлэлт(HRAM) болгон хувиргаж, ялган салтгалтыг сайжруулж мэдрэх чадварыг пикограмын түвшин хүртэл нэмэгдүүлж чадсан шийдэл юм. Энэхүү төхөөрөмж нь массын өргөн мужид 20,000м/z хүртлэх молекул масстай нэгдлүүдийн бүрэн спектрийг нэгэн зэрэг хэмжих нь хурдыг сайжруулж, илүү мэдрэмжийг хөнгөвчилдөг. TOF LC/MS-ийн массын спектрийн бүрэн хайлтын горимд нь скрининг хийх, үл мэдэгдэх нэгдлийг тодорхойлох, дэвшилтэт статистик дүн шинжилгээ гүйцэтгэх, биомолекулын шинж чанарыг тодорхойлоход шаардлагатай бүх мэдээллийг авах боломжийг олгохоос гадна нарийн төвөгтэй хольцыг салгах, илрүүлсэн нэгдлийнхээ химийн бүтцийн томъёог тодорхойлоход тусалдаг.

ULTIVO ЗАГВАРЫН ГУРВАЛСАН КВАДРОПОЛИТ LC/MS СИСТЕМ

Ultivo – нь ионыг хуйлруулан мөргөлдүүлэх буюу Vortex collision cell, циклонон ион чиглүүлэгч(Cyclone ion Guide) болон вакуумын болон ионы алдагдал үүсгэхээс сэргийлсэн VacShield зэрэг технологийн патентуудыг шингээснээрээ мэдрэх чадвар, шинжилгээний тогтвортой байдал болон бусад үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг маш сайн сайжруулсан.

6400 ЗАГВАРЫН ГУРВАЛСАН КВАДРОПОЛИТ LC/MS СИСТЕМ

6475D Triple Quadrupole LC/MS - Agilent Jet Stream технологи нь хэт халсан азотоор өндөр температурт иончлол болон десольватаци хийж уусгагчийг зайлуулан шинжилгээний үр ашгийг сайжруулж, өндөр энергийн ± 20 kV детекторын тусламжтай илүү тод дохиог барьж, дуу чимээг бууруулдаг. Энэхүү дэвшилтэт технологийн тусламжтайгаар пестицид, малын эмийн бүтээгдэхүүний үлдэгдэл, PFAS, нитрозамин болон бусад хортой нэгдлүүдийн шинжилгээнд шаардлагатай илрүүлэх хязгаарыг өдөр тутамдаа хялбархан гаргаж чадна.

6495D загварын гурвалсан квадрополи нь маш бага илрүүлэх хязгаар шаардагддаг тоон тодорхойлолтын шинжилгээнд тохирсон өдөр тутамдаа олон тооны дээжийн шинжилгээтэй, сорилын лабораториудад зориулагдсан, маш өндөр хүчин чадалтай шийдэл юм. Хамгийн сүүлийн үеийн, шинэлэг iFunnel технологиор тоноглогдсон энэхүү LC/MS/MS нь нарийн төвөгтэй матрицтай эсхүл тодорхойлоход бэрхшээлтэй анализуудын илрүүлэлтийг пиктограмын түвшинд илрүүлэх ба тухайлбал, омикс, хоол хүнс, хүрээлэн буй орчны шинжилгээ зэрэгт хүрэхийн зэрэгцээ миллисекундээс бага хугацаанд өндөр нарийвчлалтай олгодог. Масс спектрометрийн дээд зэргийн



6100 загварын нэг квадрополит LC/MS систем



6230B TOF LC/MS



Ultivo загварын гурвалсан квадрополит LC/MS систем

гүйцэтгэл нь өдөр тутмын шинжилгээнд зориулагдсанаас гадна AI хиймэл оюун ухаанд SWARM тохируулга, VacShield, засвар үйлчилгээний (EMF) хяналтын самбар, хуваарьтай тааруулах, ухаалаг рефлекс зэрэг функцууд нь систем хамгийн өндөр гүйцэтгэлтэй үед илүү удаан бүтээмжтэй, бизнесийн үр ашгийг дээшлүүлнэ.

6500 ЗАГВАРЫН МАССЫН ӨНДӨР НАРИЙВЧЛАЛТАЙ НИСЭХ ХУГАЦААНЫ LC/MS

6530B Q-TOF LC/MS – Agilent Jet Stream Ion Focusing буюу даралтат урсгалтай ионыг чиглүүлэгч технологийн тусламжтай ул мөрийн төдий агуулгатай нэгдлүүдийн илрүүлэлтийг 5-10 дахин нэмэгдүүлсэн хүчин чадалтай хүчирхэг төхөөрөмж юм. Бүрэн хайлтын MS спектр, дараа нь MS/MS эсвэл бүх ионыг бүртгэх ба түүнийг эмийн үйлдвэрлэл, биохимийн шинжилгээнд ашиглахад нэн тохиромжтой болгодог

6545XT AdvanceBio Q-TOF LC/MS – Уургийн бүрэн түвшинд хамгийн нарийвчилсан мэдээлэл, пептидийн түвшинд уургийн дараалалыг автоматаар баталгаажуулах, хөрвүүлэлтийн дүн шинжилгээг найдвартай гүйцэтгэх, шаардлагатай эсэхээс үл хамааран биоэмийн бэлдмэлийн шинж чанарыг тодорхойлох олон ажлыг зохицуулахад зориулагдсан.

6546 Q-TOF LC/MS – Динамик өргөн мужид шинжилгээний чанарыг муутгахгүйгээр нэгэн зэрэг өндөр хурд, өндөр нарийвчлалыг гаргах боломжтой бөгөөд илүү нарийн түвэгтэй шинжилгээнд илрүүлэлтийг массын өргөн мужид илрүүлэлтийг хийдэг тул хүнсний баталгаажуулалтын шинжилгээнд болон бодисын солицлооны судалгаа зэрэгт нэн тохиромжтой шийдэл юм.

6560 Ion Mobility Q-TOF LC/MS – ионы хөдөлгөөнт байдлын тусгаарлалтыг мөргөлдөөний хөндлөн огтлолын нарийн хэмжилттэй хослуулж, ижил төрлийн шалгалт тохируулгын стандартыг ашиглахгүйгээр хүндрэлтэй дээжийн талаар илүү нарийвчлалсан үр дүнг өгнө.

6560 Ion Mobility Q-TOF LC/MS - нэмэлт ялган салгалтын хэмжигдэхүүний нэмэлттэй тул ионы шилжилтийн ялгалтыг хөндлөн огтлолцон мөргөлдүүлэх нарийн хэмжигдэхүүнтэй хослуулсанаар калибровкийн стандарт шаардахгүйгээр нарийн төвөгтэй дээжийн дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн олж авах боломжтой. Энэ нь уламжлалт LC/MS системээр гарган авах боломжгүй бүтцийн мэдээллийг харах боломжтойгоос гадна ялангуяа өндөр нарийвчлалтай demuтиплексинг (HRdm) ашиглан изомеруудыг ангиллаар нь ялган салгах боломжтой. Метаболизмийн дээжийн илүү дэлгэрэнгүй профайлыг бий болгох, нарийн төвөгтэй полимер хольцыг тодорхойлох, биомолекул дахь бүтцийн өөрчлөлтийг ойлгохыг хүсч байгаа эсэхээс үл хамааран ионы хөдөлгөөнт масс спектрометр нь шинэ мэдээлэл авах боломжийг таньд олгох болно.



6546-Q-TOF LC/MS



6545XT-Advance Bio
Q-TOC LC/MS


Agilent AAS атом шингээлтийн спектрометрийн шийдлүүд

